

БАТЛАВ: ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“БЛАСТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

А.ТЭМҮҮЛИН

“БЛАСТ” ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ, ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ
ХЭРЭГЖИНЭ. “ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН
АГУУЛАХЫН ӨРГӨТГӨЛ” ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2688336

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:

ПҮРЭВ.ШИНЭЦЭЦЭГ

“БЛАСТ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ

ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Т.ЭРДЭНЭБАТ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Бласт”ХХК-ийн “Таван толгой” салбар

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт орших “БЛАСТ” ХХК-ийн “Таван толгой” салбарын “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төсөл.


Төслийн газар зүйн байрлал

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлана. Улаанбаатар хотоос баруун урагш 600 км, Даланзадгад хотоос зүүн хойш 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун урд зүгт 4.5 км зайд байрлана.

№	X	Y
1	4841049.75	542523.52
2	4841150.94	542647.55
3	4841054.05	542726.60
4	4840952.86	542602.58

Талбайн булангын цэгүүдийн газарзүйн солбилцолуудыг хүснэгтээр үзүүлэв.

Төслийн талбайн байршилын зураг



Төсөл хэрэгжүүлэгчийн товч танилцуулга

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний “Бласт”ХХК нь үйлдвэрлэлийн тэсрэх материалын хангамж, тэсрэх бодисын үйлдвэрлэл, тэсрэх материалын хадгалалт, тээвэрлэлт, тэсэлгээний ажлын үйлчилгээ эрхэлдэг улсаа томоохон компанийн нэг юм. “Бласт”ХХК нь 2001 онд байгуулагдсанаасаа хойш дээрх үйл ажиллагааг тасралтгүй явуулж байгаа үндэсний компани юм. Төсөл боловсруулагчийн товч танилцуулга

“Бласт” ХХК-ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын Таван толгой”салбар нь 2009 онд байгуулагдсан бөгөөд тус салбар нь 2015 оноос 2021 он хүртэл үйл ажиллагаа зогсож, 2021 оны 03 дугаар улирлаас үйл ажиллагаа дахин явуулж эхэлсэн.



“БЛАСТ”ХХК-ний “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
Тэсрэх бодис үйлдвэрлэлийн ерөнхий ойлголт

Энгийн найрлагатай тэсрэх бодис:

Энгийн найрлагатай тэсрэх бодис /цаашид ANFO гэх/ нь сүвэрхэг аммиакийн шүү ба шатах хольцоос тогтсон тэсэлгээнд зориулсан өртөг багатай тэсрэх бодис юм. Хэрэглэгчийн хүсэлтийн дагуу /ANFO/-ыг зориулалтын холигч цэнэглэгч авто машинаар тэсэлгээний талбайд бэлтгэнэ.



Задгай эмульсийн тэсрэх бодис:

Үл холилдох хоёр шингэн нэг нь нөгөөдөө жигд тархсан систем юм. Усан ба тосон уусмалын нэгдэл бүхий усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодис нь гадаад байдлаараа зуурмаг, шингэн төл өвт байх ба тэсрэлтийн чадал болон бусад үзүүлэлт, хэрэглэх нөхцөл, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааны нэгдүгээр ангилалд хамаарна.

Энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис:

Энгийн тэсрэх бодисын хүчийг нэмэгдүүлэх зорилгоор энгийн тэсрэх бодисыг хольж энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис болгодог. Хольц нь ANFO-ны орцын хувиас хамааран 2 төрөл байна. ANFO нь 50-иас бага хувиар орвол энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис /BLEND/ юм. ANFO нь 50-иас их хувиар орвол хүнд анфо буюу /Heavy ANFO/ болно. Дээрх 2 төрлийн хольцыг үйлдвэр болон тусгай зориулалтын цооног цэнэглэгч авто машинд бэлтгэж, үйлдвэрлэнэ.



Үйлдвэр цогцолборын барилга байгууламж:

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын барилга байгууламжийг үйлдвэрийн хүчин чадал, үйлдвэрийн шаардлагатай аюулгүйн зай талбайн хэмжээнд тулгуурлан байгуулсан. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрт доорх барилга байгууламжууд байх бөгөөд нийт 4.47 га талбайг хамарна.



“Бласт” ХХК-ийн үйлдвэр агуулах



Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр



Химийн бодисын агуулах



Түүхий эд, тэсрэх материалын агуулах



Уурын зуух



Үйлдвэр агуулах



Авто засвар, угаалга



Цахилгааны эх үүсвэр

Цогцолборын агуулахын хашаанд түүхий эд, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалттай 20 тн-ын багтаамжтай, доторлогоо, агааржуулах цонх, хоолой гаргаж, халалт, хур тунадасаас хамгаалж давхар дээвэрлэсэн 18 ш төмөр чингэлэгийг хамгаалалтын далан дунд байрлуулсан. Аж ахуйн агуулах нь 20 тн-ын багтаамжтай, 2 чингэлэгээс бүрдэнэ.

Усан хангамж

Худаг өргөтгөлийн станцууд, усны тоолуур /Насосны хүчин чадал, марк/

Худаг	Байршил	Гүн	Ундарга л/сек	Тоолуур	Гаргасан он
Бласт-ТТ	43°42'14''N 105°31'48''E	120	0.8	LXSG-50	2010

Таван толгой салбарын Үйлдвэрийн цогцолборын дэргэдэх худаг



“БЛАСТ”ХХК-ний “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэсний дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “хамааралгүй” гэж бөглөнө.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэр	“Бласт” ХХК
	Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011125047
	Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Тэсрэх материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, импортлох, худалдаалах
	Аж ахуй нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө- 13,3 дугаар давхар
	Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Гүйцэтгэх захирал А.Тэмүүлэн Холбоо барих утас: 99112528 temuulen@blastcompany.mn
	Хариуцсан мэргэжилтэн, нэр, утас, цахим шуудангийн хаяг	Байгаль орчны ажилтан Т.Эрдэнэбат Холбоо барих утас: 90002470 erdenebat.t@blastcompany.mn
1.2	1.Төслийн нэр	“Таван толгой” салбар
	2.Төслийн нэр харьяаллын байршил	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан овоо баг
	3.Төслийн ангилал	Үйлдвэр
	Төсөл эхэлсэн огноо	2009
	ГЭЗҮ батлагдсан огноо	2024 он
	Урьд оны бүтээгдэхүүний хэмжээ	ЭТБ784917.33
	Ажилчдын тоо	1 ээлжинд 65 ажилтантай. нийт 130
Тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэрийн хүчин чадал	120тн/хоногт	

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлт

Төслийн сөрөг нөлөөллийн тодорхойлолт “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн үйл ажиллагааны үед байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх технологийн үе шатуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Түүхий эдийг тээвэрлэх авч ирэх;
2. Тэсрэх бодисыг үйлдвэрлэх;
3. Уурхайн талбай руу тээвэрлэх;
4. Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал;
5. Төслийн талбайн эргэн тойронд шинээр шороон зам бий болгох;
6. Технологийн болон ахуйн гаралтай хог хаягдлын цэг-талбай;
7. Уурын зуух, цахилгаан үүсгүүр ажиллуулах;

Төслийн үйл ажиллагаа нь 4.86 га талбайд явагдана. Талбайд хөрс, ургамлан бүрхэвч эвдрэлд өртөх болно. Төслийн үйл ажиллагаанаас экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг энэ хэсэгт хамруулсан.

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосонцор болон хийнүүд нь салхиар зөөгдөж тухайн газар орчмын агаарыг бохирдуулахаас гадна орон нутгийн байгаль орчин, хүн, амьтанд зохисгүй нөлөөлдөг. Үйлдвэрийн барилгын ажлын үед болон үйлдвэрийн үйл ажиллагааны үед машин механизмуудын хөдөлгүүрээс ялгарч буй дутуу шаталт, хатуу шингэн хог хаягдлын ялзралын дүнд үүсэх хорт хийнүүд нь агаарын бохирдлыг үүсгэгч шууд болон дам хүчин зүйлс болж болдог.

“Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт сөргөөр нөлөөлөх үндсэн 3 нөлөөлөл байна. Үүнд:

- Төсөлд ашиглагдаж байгаа машин механизм, дизель станциас ялгарах бохирдуулагч бодисууд;
- Төслийн талбай болох химийн бодисын агуулахуудын хамгаалалтын далангаас тоос дэгдэж агаар орчинд тархана;
- Үйлдвэрийн түүхий эд болон бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд агаар мандалд гарах тоосны хэмжээ хуурайшлын үед нэмэгдэх, зөөгдөх;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдэх нь агаарын чанар, шуугианы бохирдлын түвшинг ихэсгэнэ;
- Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдал агаар орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

“Бласт” ХХК-ийн “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, тэсрэх материалын агуулах”-ийн талбай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлана. Улаанбаатар хотоос баруун урагш 600 км, Даланзадгад хотоос зүүн хойш 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун урд зүгт 4.5 км зайд байрлана. Тухайн төслийн үйл ажиллагаа явуулдаг нийт талбайн хэмжээ нь 4.86 га болно.

“Бласт” ХХК-ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулах”-ийн талбай нь газрын гадаргын хувьд тэгш, хэрчигдэл, гуу жалга байхгүй цөлжүү хээрийн цайвар бор хөрстэй байна.

Төслийн талбайн жижиг аараг толгод бүхий нугачаад хөндийд байрлах бөгөөд эдэлбэр газрын гадаргын хувьд тэгшилж зассан байна. Төслийн талбайн урд талаар Таван толгойн нүүрсний ил уурхай, овоолгууд хүрээлнэ.

“Бласт” ХХК нь төслийн талбайд энэхүү тайлангийн 3-р бүлэгт тодорхойлсон барилга байгууламжуудыг байгуулсан байна. Үүнд:

- Химийн бодисын агуулахууд (сендвичен барилга ба чингэлэгүүд);
- Үйлдвэр болон оффис, бусад байгууламжууд;
- Дизель түлшний агуулах (газарт булсан);
- Цементэн талбайнууд;
- Чингэлэгүүд
- Хамгаалалтын шороон далангууд;
- Хамгаалалтын шуудуу;
- Хогийн цэг;
- Туршилтын талбай;
- Тэсрэх бодис ба тэсрэх хэрэгслийг уурхайн талбайд хүргэх шороон зам

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн судалгаа:

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах “Бласт” ХХК-ийн тэсрэх бодисын агуулахын талбай нь сумын төвөөс баруун өмнө зүгт 3 км-т байршилтай, Нүүрс тээврийн хатуу хучилттай замын зүүн талд. Агуулахын талбай, түүний орчмын гадаргаар Сайргархаг Бор хөрс (сайр чулуутай), нам доор хөндийн хэсэгт Хужир мараалаг хөрс тус тус тархсан.

Аймаг, сум: Өмнөговь аймаг, Цогтцэций сум

Газрын нэр: Талбайн өмнөд хэсэгт

Координат: ХӨ 43.704020

ЗУ 105.52850 Өндөр, д.т.д (метр): 1542 м

Хөрсний хими шинж чанар

Дээжний дугаар	Гүн, см	pH _{H₂O} (1:2.5)	CaCO ₃ %	Ялзмаг %	EC _{2.5} dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
						P ₂ O ₅	K ₂ O
Зүсэлт-1	3-18	7.88	0.00	0.325	0.092	0.52	5.2

Талбайд 2009 оноос эхлэн тэсрэх бодисын агуулах, үйлдвэрийн зориулалтаар ашиглаж байна. Хөрсний органик бодисын агууламж 0.325% буюу ижил хэв шинжийн хөрсний түвшин (1%- бага) хэвийн. Хөрсний урвалын орчин сул шүлтлэг (7.88), өнгөн үеээс карбонат илрээгүй, хялбар

уусах давсны агуулга маш бага, давсжилтгүй (0.092 dS/m), хөдөлгөөнт элементүүд ижил хэв шинжийн хөрсний түвшинтэй харьцуулбал бага агууламжтай.

Хөрсний физик шинж чанар

Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
		Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)
Зүсэлт-1	3-18	68.6	23.4	8.0

Тухайн хөрсний 3-18 см-ийн үе давхаргад эзэлхүүн жин 1.42 г/см² байгаа ба хөрсний үе давхаргууд элсэн ширхэг давамгайлж элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй

Хөрсний хүнд элементүүдийн агуулга

Зүсэлтийн дугаар	Гүн, см	Хүнд элементүүд, мг/кг					
		Ni	Pb	Cd	Cr	Zn	Cu
1	0-10	29.2	13.8	0.0	31.4	80.9	100.3
Стандарт MNS5850-2008		150	100	3	150	300	100

Талбайн өмнөд хэсгээс авсан хөрсний зарим элементүүд хүнд элементүүдийн (Зэсээс бусад элементэд хамаарагдана) агуулга стандарт (Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008) хэмжээнд буюу бохирдолгүй байна. Харин хөрсөнд агуулагдаж буй зэсийн агууламж 0.3 мг/кг буюу бага бохирдолтой гэж үзэж байна

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Төслийн талбайн ургамлан нөмрөгийн судалгаа:

Дээрх үйлдвэрийн эзэмшил талбайд хийсэн судалгааны үр дүнд нийт 9 овог, 17 төрөлд хамаарах 23 зүйлийн ургамал бүртгэгдэв.

Төслийн талбайд бүртгэгдсэн ургамлын жагсаалт

д/д	Латин нэр	Монгол нэр
I. Gramineae Juss. - Үетний овог		
1	<i>Stipa gobica</i>	Говийн хялгана
2	<i>Cleistogenes songorica</i>	Зүүнгарын хазаар өвс
II. Liliaceae Juss. - Сараанын овог		
3	<i>Asparagus gobicus</i>	Говийн хэрээн нүд
III. Polygonaceae - Тарнын овог		
4	<i>Rheum nanum</i>	Намхан гишүүнэ
VI. Chenopodiaceae Vent. - Луулийн овог		
5	<i>Bassia dasyphylla</i>	Үслэг манан-хамхаг
6	<i>Corispermum mongolicum</i>	Монгол хамхуул
7	<i>Chenopodium album</i>	Цагаан лууль
8	<i>Echinopsilon divaricatum</i>	Дэрвэгэр мананхамхаг
9	<i>Halogeton glomeratus</i>	Баг хуш-хамхаг
10	<i>Salsola collina</i>	Толгодын бударгана
11	<i>Salsola pestifer</i>	Өргөст бударгана
V. Rutaceae Juss. – Хүж өвсний овог		
12	<i>Haplophyllum dauricum</i>	Хүж өвс
VI. Leguminosae Juss. – Буурцагтан		

13	<i>Caragana pygmaea</i>	Тарваган харгана
14	<i>Astragalus monophyllus</i>	Ортууз
VII. Zygophyllaceae - Хотирын овог		
15	<i>Peganum nigellastrum</i>	Харлаг үмхий өвс
VIII. Labiatae - Уруул цэцэгтэн		
16	<i>Lagochilus ilicifolius</i>	Ямаан ангалзуур
IX. Compositae Giseke. – Нийлмэл цэцэгтэн		
17	<i>Artemisia pectinata</i>	Шүлхий шарилж
18	<i>Artemisia ruthifolia</i>	Шаргал шарилж
19	<i>Artemisia xerophytica</i>	Хуурайсаг шарилж
20	<i>Artemisia macrocephala</i>	Царван шарилж
21	<i>Artemisia xanthochroa</i>	Татанхай шаваг
22	<i>Artemisia scoparia</i>	Улаан шарилж
23	<i>Scorzonera pseudodivaricata</i>	Хуурамч дэрэвгэр хависгана

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Төслийн хамгаалалтын шороон далан, шуудуу байгуулах үйл ажиллагаа нь хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавьжын зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчинг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ.

Төсөлд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад төслийн талбай орчмоос дайжих, жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах тохиолдол гарна.

Төслийн ахуйн хаягдлыг ил байршуулсан тохиолдолд хэрээ, шаазгай, элээ зэрэг хаягдал шүтэн амьдардаг шувууд цуглаж болзошгүй.

Төслийн үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, хөрс бохирдохын хирээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан амьтны аймгийн амьдрах орчин доройтож, идэш тэжээл нь хомсдож, тархац, газар нутгийн хэмжээ хумигдана. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурахад нөлөөлнө.

Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан дуу чимээ, тоос гарах, усны нөөц багасах, бэлчээрийн доройтол болох зэрэг сөрөг үзүүлэлт гарснаар зэрлэг ан амьтад мөн сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Зарим төрлийн шавьжийн амьдрах орчинг устгах;
 - Төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих;
 - Төслийн зам тээврийн үйл ажиллагаанаас зарим амьтдын популяцын тусгаарлалт үүсэж, амьтдын нүүдэлд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлнэ;
 - Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтад сөрөг нөлөөлөл учруулна.
- Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө.

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Гадаргын ус

Төслийн талбай болон түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөхөөр гадаргын ус байхгүй болно.

Газрын доорх ус

“Бласт” ХХК-ийн Тавантолгой салбар нь өөрийн мэдлийн 1 гүний худагтай байна. Тус худгаас төслийн нийт усны хэрэгцээг хангадаг байна

Ээжний дугаар	Координат	Уст цэгийн төрөл
1	4839113,3 542506,5	Гүний худаг

Энэхүү уст цэгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, холимог бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү хатуу ус байна. Сорьцонд хуурай үлдэгдэл 1.28 мг/дм³, ерөнхий хатуулаг 10.21 мг/экв, рН-7.89, исэлдэх чанар 13.12 мг/дм³ байна.

Шинжилгээний дүнг хүснэгтээр үзүүлэв.

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг/л	мг/экв	мг-экв/л		мг/л	мг/экв	мг-экв/л
Cl⁻	217.26	6.12	34.19	Na⁺+ K⁺	174.17	7.57	42.30
SO₄²⁻	0.16	7.88	44.01	NH₄⁺	0.70	0.04	0.22
NO₃⁻	6.31	0.10	0.57	Ca²⁺	142.68	7.12	39.78
NO₂⁻	0.05	0.00	0.01	Mg²⁺	27.57	3.09	17.26
CO₃²⁻	0.00	0.00	0.00	Fe²⁺	1.00	0.04	0.20
HCO₃⁻	231.88	3.80	21.23	Fe³⁺	0.80	0.04	0.24
Дүн	455.66	17.90	100.00	Дүн	356.92	17.90	100.00

Усны химийн задлан шинжилгээний дүн

Тус төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн газрын доорх усанд дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Газрын доорх усны нөөцийн хомсдол үүснэ;
- Цэнгэг усны нөөцийг ашиглана;
- Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бохир усны алдагдал, нэвчилгээс бага гүний уст үеүд бохирдох;
- Хаягдал ус цэвэршүүлэх байгууламжид гарч болзошгүй эвдрэл гэмтэл нь цэвэршүүлээгүй усыг байгальд хаяж, ингэснээр бохир ус газрын доорх усанд нэвчин бохирдуулах;
- Тус тэрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор нь унд-ахуйн хэрэгцээндээ жилд 814.5 м³, үйлдвэрлэлийн хэрэгцээндээ жилд 3040.8 м³ ус хэрэглэдэг байна. Жилд ойролцоогоор 3855.3 м³ ус хэрэглэдэг ;
- Тухайн цогцолбор нь хэрэгцээт усаа худгаас машинаар зөөн авчирч 25 м³ багтаамжтай 2 төмөр саванд нөөцөлж хэрэглэдэг болно;
- Үйлдвэр болон ажилчдын байр, душны бохирыг газар доор байрлуулсан 25 тн-ын багтаамжтай 2 ш битүүмж сайтай саванд түр байршуулж 5 тн даацтай бохирын машинаар соруулан орон нутгийн харьяа цэвэрлэх байгууламжид гэрээгээр нийлүүлүүлдэг.

Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Тусгай хамгаалалттай газар гэж байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор тодорхой хэмжээний газар нутгийг улс болон орон нутгийн захиргааны хамгаалалтад авсныг хэлнэ. МУ-ын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийг дараахь байдлаар ангилна. Үүнд:

1/ дархан цаазат газар;

2/ байгалийн цогцолборт газар; 3/ байгалийн нөөц газар (БНГ); 4/ дурсгалт газар.

Төслийн талбай нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газарт хамаарахгүй байна.

“Бласт” ХХК-ийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын “Тавантолгой” салбарын талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байрлана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

“Бласт” ХХК-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан”, “Байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайлан”, 2024 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүгнэлт”, холбогдох журам зэргийг мөрдлөг болгон байгаль орчинд үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, үүрэг даалгавруудыг биелүүлэхэд байгаль орчны менежментийн зорилго оршино.

БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад технологийн болон удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсэж болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн БОНБНҮ-ний тайланд тусгагдсан зөвлөмж, холбогдох хууль дүрэм журам стандартуудыг мөрдөн ажиллах юм.

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

2.2. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

2.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

2.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

2.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх хэлбэр	Хамрах хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1.1 Агаар							
1	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замаас үүсэх тоосжилтыг бууруулахад хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх, GPS-ийн мэдээнд хяналт тавих	Тээврийн хэрэгслийн шороон замаар зорчих хэсэгт	Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаас	Төслийн хугацаанд	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2		Төслийн үйл ажиллагаанаас гарах тоосжилтыг бууруулах усгалгааг тогтмол хийх					
		Олон салаа зам үүсгэж тоосжилт үүсгэх нөхцөлийг багасгаж замын хөдөлгөөний зохицуулалтын тэмдэг тэмдэглэгээ байршуулах					
3	Авто машины шатах тослох материалын ууршилт, утаа хорт хий агаар орчинг бохирдуулах	Ашиглагдаж буй машин механизм, техникийн засвар, үйлчилгээ тогтмол хийх	Цогцолборын хэмжээнд	Тогтмол	Үйл ажиллагааны зардлаас	2026 онд	
Нийт зардал					210'000		

Хөрс чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх хэлбэр	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1.2 Хөрсөн орчинд							
1	Төслийн талбайд хог хаягдлыг ил задгай хаях, хөрс бохирдуулах	Хог хаягдлын менежментийн сургалт зохион байгуулах, мэдлэг олгох	Ажилчдад	1 удаа	-	2026 онд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2	Шатахууны асгаралт, гоожилтоос хөрсөнд нэвчилт үүсэх	Шатахуун агуулах хэсгийн шороон талбайг бетондох	Үйлдвэр	1 удаа	2.500.000	2026 онд	
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрсний бүтэц эвдэгдэх	Химийн бодисын тээвэрлэх маршрутын дагуу зам засвар арчилгаа хийх	Төслийн талбайд	-	3.000.000	2026 онд	
Нийт зардал					5.500.000		

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба тавтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1.3. Усан орчинд							
1	Урт хугацаанд хэмнэлтгүй ашигласнаар усны нөөц хомсдох	Гүний усны түвшин хэмжилтийг тогтмол хийж, хяналт тавих	Ажилчид	Тогтмол	Дотоод зардлаар	2026 онд	Байгаль орчныг хамгаалах тухай, Усны бохирдуулсны төлбөрийн тухай хууль
2	Зөвшөөрөлгүй ус ашиглах, усны нөөц ашигласны төлбөр бүрэн төлөгдөхгүй	Ус ашиглалттай холбоотой дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл авч ажиллах	Цогцолборын хүрээнд	1		1-4 сард	
3	Хаягдал усны дүгнэлт, ус зайлуулах гэрээ, зөвшөөрөлгүй ариутгах татуургад болон байгальд шууд нийлүүлэх	Холбогдох байгууллагаас хаягдал усны дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл авч ажиллах	Цогцолборын хүрээнд	1		2-5 сард	
4	Усны илүү ашиглалт	Сар бүрийн 25-нд ус ашиглалтын тоолуурын акт баталгаажуулалт хийлгэж төлбөрийг тухай бүрт төлөх	Цогцолборын худаг	12 удаа		2026 онд	

Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1.4. Ургамлан орчин							
1	Ургамлан бүрхэвчийн доройтол илрэхгүй байх	Ургамлын хяналт мониторингийн хатуу цэг тогтоож мониторинг хийх	Үйлдвэр, Амрах байр	-	Дотоод зардлаар	4-8-р сард	БОННУ 9.7-р зүйл байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах.
1.5. Амьтан							
2	Хээрийн ан амьтан өлдөж үрэгдэх	Зэрлэг ан амьтдын амьдрах орчинг сайжруулахаар Биотехникийн арга хэмжээ	Цогтцэций суманд	1.2 тонн	1.200.000	2026 онд	Амьтны тухай хуулийн 6.1.8 Био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
3	Шувууны хоргодол бий болох	Шувуу үргээгч тоног төхөөрөмж ашиглах	Үйлдвэр	2	70'000	2026 онд	
4	Хээрийн ан амьтан өлдөж үрэгдэх	Зэрлэг ан амьтан асран хамгаалах төвийн зураг төсөв боловсруулж, ажлыг эхлүүлэх ажилд хамтран оролцох	Төслийн хэмжээнд	-	-	2026 онд	
Нийт зардал					1'270'000		

БҮЛЭГ 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо /хэмжих нэгж/	Нийт зардал /Сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах журам стандарт	хууль
1	“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд хөрс, уур амьсгалд тохирсон суулгацыг тарих, усалгаа, арчилгаа хийж нөхөн тарилтыг хийх	Төслийн талбайд	1000	3.000.000	2026 он	Байгаль хамгаалах тухай хууль хөдөлмөрийн тухай хууль, аюулгүй ажиллагааны дүрэм, журам Тайланд тусгагдсан бүх хууль, дүрэм, стандартын хүрээнд	
2	Ус гадагшлуулах үерийн суваг хийж талбайн дэд бүтцийг сайжруулах, хөрсний эвдрэл, ус тогтож газар доройтохоос урьдчилан сэргийлэх	Үйлдвэрийн талбай	-	Дотоод зардлаар	2026 он		
3	Цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, Нүүрсхүчлийн хийн ялгаруулалт ихсэх	Үйлдвэр, агуулахын хэсэгт гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүч бүхий нарны панельтай LED гэрэл ашиглах	-	1.500.000	2-р улиралд		
4	Цогтцэций сумын тармаг ой бүхий хэсэгт 1 га-аас доошгүй талбайд заг тарих (Сумаас мод тарих талбайг заалгаж бэлтгэл ажлыг хангах)	Цогтцэций сумын нутагт	-	Дотоод зардалаар	2026		
	Нийт зардал			4.500.000			

БҮЛЭГ 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ
Хамаарахгүй

БҮЛЭГ 5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
Төслийн талбайн болон түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй.

Төсөл хэрэгжүүлэх явцад түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хирэгсүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоож хамгаалалт гарган холбогдох байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хмагаалганд авах шаардлагатай. Эдгээрийг дараах байдлаар дэлгэрүүлнэ.

“Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай” М онгол улсын хуулийн зуравдугаар бүлгийн 12, 13-р зүйлд заасны дагуу газрын хэвлийг ашиглах явцад археологийн олдвор болон түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл гүйцэтгэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга болон цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг шинжлэх ухаан болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтын зөвшөөрөлгүйгээр хөдөлгөхийг хориглоно гэсэн заалтыг мөрдлөг болгоно.

БҮЛЭГ 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бодис, материалыг тоо хэмжээ, шинж чанараас хамааруулж агуулахуудад ангилж хадгалдаг. Агуулахын барилгуудыг холбогдох стандарт MNS6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн агуулах ерөнхий шаардлагад нийцүүлэн байгуулсан ба осол аюулын эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтийг холбогдох байгууллагаас гаргуулах замаар хүний буруу үйл ажиллагааны улмаас хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн ашиглалтын бүхий л үе шатанд байгаль орчин, хүний эрүүл мэндэд тохиолдож болзошгүй осол, аюул эрсдэл гаргахгүй байхад чиглэсэн үйл ажиллагааг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажилладаг.

Тэсрэх бодисын үл тэсрэх хольц бэлтгэх үйлдвэр нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд онцгой анхаардаг бөгөөд Монгол улс болон ОУ-ын хэмжээнд мөрдөгдөх хууль, журам, арга технологи болон компанийн дотоод журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

- Дотоод хяналт шалгалт хийх журам
- Нэвтрэн орох гарах журам
- Галын аюулгүй байдлыг хангах журам
- Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, хэрэглэх түүнд хяналт тавих журам
- Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
- Гамшгийн эрсдлийн үнэлгээ
- Гал унтраах шуурхай төлөвлөгөө

“БЛАСТ”ХХК-ийн “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Осол эрсдэлийн менежмент

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
7.1	Агуулахын дүрэм, журам, хадгалалтын горим, нөхцөл зөрчигдөх	Химийн бодисын агуулахад тогтмол үзлэг, хяналт тавих	Агуулахад	-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш	- Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт шинжилгээ MNS 5080:2001 стандарт Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
7.3	Хөдөлмөрийн аюулгүй байдал зөрчигдөх	Химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл, урьдчилан сэргийлэх ерөнхий сургалт, зааварчилгаанд хамруулах	Үйлдвэрийн ажилчид	-	1.500.000	2026 онд	
7.4	Галын осол аваараас урьдчилан сэргийлэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, зохион байгуулах	Нийт ажилчид	-	2.000.000	1 удаа	
7.5	Маршрутын бус замаар зорчих, гэнэтийн осол асгаралт үүсэх	Маршрут батлуулах	Салбараас уурхайн хооронд	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 онд	
Нийт зардал					3.500.000		

БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын засаг даргын 2021 оны А/51 тоот Хог хаягдал түр хадгалах цэг тогтоох тухай захирамжийн дагуу хог хаягдал хөрсөнд нэвчихээс сэргийлж бетондсон шалтай, 4 үндсэн тасалгаатай хог хаягдал ангилан хадгалах нэгдсэн цэгийг үйлдвэрээс 150 метрийн зайд байгуулсан бөгөөд үйлдвэр агуулахын үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг түр хадгалж гэрээт байгууллагуудад шилжүүлэн ажиллана.

Цогтцэций суманд хоёрдогч түүхий авах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч “Дүүрэн Цэций” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, үйлдвэрээс үүсэх дахивар хог хаягдлыг нийлүүлдэг. 2026 онд тус гэрээг сунган хамтын ажиллагаа үргэлжлүүлэх ажиллах төлөвлөгөөтэй.

Ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх гэрээг жил бүр “Сток Бласт” ХХК-тай, Бохир ус тээвэрлэлтийн гэрээг “Өгөөмөр дэлгэр ширээт” ХХК-тай тус тус байгуулж, ахуйн бохир усыг Цогтцэций суман дахь “Ухаа худаг” ус хангамж ХХК-ийн цэвэрлэх байгууламж хүртэл тээвэрлүүлж ажилладаг бөгөөд 2026 онд холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллана. Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээг “Түмэн эгшиг” ХХК-тай жил бүр байгуулж, “АХХ-ыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах” журам, болон гэрээний дагуу шилжүүлэн ажиллана.

Шингэн хаягдал

Тус төслийн үйл ажиллагаанаас дараах төрлийн шингэн хог хаягдал гарна. Үүнд:

- Үйлдвэрийн тоног төхөөрөмж шал, угаасан бохир ус.
- Ариун цэврийн өрөөнөөс гарч буй бохир
Үйлдвэр болон ажилчдын байр, душны бохирыг газар доор байрлуулсан 25 тн-ын багтаамжтай 2 ш, 15 тн-ын багтаамжтай 1 ш битүүмж сайтай саванд түр байршуулж 5 тн даацтай бохирын машинаар соруулан орон нутгийн харьяа цэвэрлэх байгууламжид гэрээгээр нийлүүлүүлдэг.

Технологийн гаралтай хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас дараах төрлийн технологийн гаралтай хог хаягдлууд гарна. Үүнд:

- Түүхий эдийн шуудай;
- Түүхий эдийн болон тэсрэх хэрэгслийн цаасан хайрцаг
- Химийн бодисуудын сав, баглаа боодлын хаягдал;
- Техникийн тосны хоосон төмөр торх (бочка);
- Тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, тосолгооны бүтээгдэхүүний хаягдал;
- Автомашины шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн хаягдал.

“БЛАСТ”ХХК-ийн “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
8.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө							
Ахуйн хог хаягдал							
8.1	Хог хаягдал салхинд хийсэх, хөрсөнд нэвчилт үүсгэх	Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардал	Улиралд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль 9.2. Хог хаягдлын үйлчилгээний хураамж 20 дүгээр зүйл .1 Хог хаягдлын үйлчилгээний хураамж 24дүгээр зүйл.1 Журам
8.2	Зөвшөөрөлгүй хаях, хүрээлэн буй орчин бохирдуулах	Хог хаягдлын гэрээ байгуулж, ахуйн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх		-		2026 онд	
8.3	Хог хаягдлыг ангилахгүй хаях	Хог хаягдал түр хадгалах цэгийн энгийн ахуйн хаягдлын хэсгийн ангилан ялгалтын тасалгаа хийх		-	2.500.000	1-р улиралд	
8.4		Дахивар хог хаягдлыг ангилан ялгаж, түүхий эд авагч байгууллагад нийлүүлэх		-	-	Тайлант онд тухай бүр	
		Хог хаягдлын 3-с доошгүй төрлөөр ялгах, ангилан ялгалтын сав нэмэгдүүлэх		-	700.000	2026 онд	

“БЛАСТ”ХХК-ийн “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Үйлдвэр, аюултай хог хаягдал							“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах”
8.5	Зөвшөөрөлгүй ил задгай хаях, хүрээлэн буй орчин бохирдуулах	Эрх бүхий байгуулагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, түүхий эдийн сав баглаа боодлыг шилжүүлэх	Төслийн талбайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардал	2026 онд	
8.7	Хог хаягдал салхинд хийсэх, хөрсөнд нэвчилт үүсгэх	Аюултай хог хаягдал түр хадгалах цэг түүний орчимд ариутгал хийх		-		Тухай бүр	
Нийт					3’200’000		

БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчилан тогтоох боломжтой болно. Хяналт шинжилгээний дээж, сорьцийг МУ-ын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан арга зүй, стандартын дагуу шинжлүүлнэ.

№	Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа	Зардал /төг/	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаар					
1	Тоосжилт (PM10, PSM, PM25) Гадаад, дотоод орчин	Амрах байр, Үйлдвэр	4,9 сард	300*000	MNS4990:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн
Ус					
2	Усны ерөнхий химийн шинжилгээ болон нян судлалын ерөнхий шинжилгээ	Амрах байр, Үйлдвэр	4, 9 сард	320*000	MNS 0900 : 2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй
3	Хаягдал усны шинжилгээ	Амрах байр, Үйлдвэр	4,9 сард	320*000	MNS 6561 : 2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
Хөрс					

“БЛАСТ”ХХК-ийн “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Хөрсний механик бүрэлдэхүүн агрохимийн шинжилгээ	Амрах байр, үйлдвэрийн байрны хажуугаас, шатахуун түгээгүүр орчим, хог хаягдлын цэгийн орчим	4,9 сард	200'000	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
5	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ		4,9 сард	200'000	
6	Хөрсний хүнд металлын шинжилгээ		4,9 сард	400'000	
7	Хаягдал үнсэнд цацрагийн шинжилгээ	Уурын зуухны хаягдал үнс	4-р сард	300'000	Хог хаягдлын тухай хууль
Нийт зардал				1'740'000	


“БЛАСТ”ХХК-ийн “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Д/д	Х	Ү
Хөрсний мониторингийн цэгүүд		
1	542605.1128	4839044.492
2	542617.5483	4839148.738
3	542658.2942	4839014.065
4	542707.2422	4839197.422

Агаарын мониторингийн цэгүүд

1	Үйлдвэрийн хашааны гадна
2	Үйлдвэрийн хашааны дотор
3	Үйлдвэр дотор
4	Хогийн цэг

Д/д	Өргөрөг	Уртраг
Усны мониторингийн цэгүүд		
1	46°01'18.6"N,	101°13'20.8"E



Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэгүүдийн байршилг хүснэгтээр болон сансрын зургаар үзүүлэв

БҮЛЭГ 9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг “БЛАСТ” ХХК-ийн удирдлага хүлээнэ.

		Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо /хэмжих нэгж/	Нийт зардал /Сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль стандарт	журам
1		Байгууллагын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ирээдүйд үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	Менежментийн төлөвлөгөөний зардал хөрөнгийг төсөвлөн, санхүүжүүлэх	Дотоод зардлаар		2026 он	Байгаль хамгаалах тухай хууль хөдөлмөрийн тухай хууль, аюулгүй ажиллагааны дүрэм, журам Тайланд тусгагдсан бүх хууль, дүрэм, стандартыг н хүрээнд	
2	Удирдлага зохион байгуулалт	Сум орон нутагт хөрс бохирдуулагч нүхэн жорлонг бууруулах ажлыг зохион байгуулах	Өмнөговь аймаг, Цогтцэций сум	2	3.500.000	2026 онд		
3		Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд зохион байгуулах		3	Дотоод зардалаар	2026 онд		
Нийт зардал					3.500.000			

**БҮЛЭГ 10. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ
ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ**

“Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, тэсрэх материалын агуулах,” цогцолборын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх үүрэг хүлээсэн бөгөөд төслийн БОМТ, түүний хэрэгжилтэнд олон нийтэд хүртээмжтэй ажил хэрэгжүүлнэ.

№	Оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Хугацаа, давтамж	Зардал /төг/
1	Орон нутгийн удирдлага, Цагаан-Овоо багийн иргэд	Багийн удирдлагуудад 2026 оны БОМТ-г хүргүүлэх, мэдээлэл өгөх	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал
2	Өмнөговь аймгийн Байгаль орчны газарт	2026 оны БОМТ-ний биелэлтийн гүйцэтгэл тайланг цахимаар болон хэвлэж хүргүүлэх	11-р сард, Жилд 1 удаа	

Өмнөговь аймгийн Цогтцэций суман дахь “БЛАСТ” ХХК-ийн “Тавантолгой” дахь салбарын 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал /төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	6.980.000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	4.500.000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3.500.000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3.200.000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.740.000
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	3.500.000
	Нийт дүн	23.420.000

“БЛАСТ”ХХК-ийн “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

 **МОНГОЛ УЛС**
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ



2006.01.19 /Бүртгэсэн өн. сар. өдөр/ 9011125047 /Улсын бүртгэлийн дугаар/

2680336 /Регистрийн дугаар/

Бласт Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тогтоол 001 2001.09.11
/Шийдвэрийн нэр/ /дугаар/ /он. сар. өдөр/

281200 /код/ Гэсрэх материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, импортлох, худалдаалах
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

511001 /код/ Гадаад худалдаа

/код/ /Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй 3 11,700.0
хугацаа /Гишүүдийн тоо/ /Өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Хан-Уул, 1-р хороо, Чингэсийн өргөн чөлөө, "Пийс Бридж" зочид буудал - 203 тоот, утас: 325996,
утас: 324044, факс:
/Хуулийн этгээдийн албан ёсны хаяг/





Гэрчилгээг олгосон: 2006 он 01 сар 19 өдөр
УХА0175

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

2022. оны .12. сарын 23. өдөр

Дугаар 864

Улаанбаатар хот

Эрхлэх үйл ажиллагааны төрөл

Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр

“БЛАСТ” ХХК

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Ландмарк оффис, 3 давхар

Регистрийн дугаар

2688336

Тусгай зөвшөөрлийн хугацаа

5 /Тав/ жил

Тусгай нөхцөл, шаардлага

Холбогдох хууль, журам, дүрэмд заасан бүх шаардлагыг хангаж ажиллах

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 202 . 2 оны . .12. сарын . 23. өдрийн А/314 дугаар тушаалыг үндэслэн олгов.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД



Ж. ГАНБААТАР

“БЛАСТ”ХХК-ийн “ТАВАН ТОЛГОЙ” дахь салбарын Үйлдвэр, агуулах төслийн 2026 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Химийн хорт болон аюултай бодисыг
Импортлох, Худалдах, Ашиглах 0002031
дугаартай тусгай зөвшөөрлийн хавсралт**

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томъёо	CAS дугаар	Зөвшөөрсөн хэмжээ, тн
1	Натрийн нитрат	Sodium nitrate	NaNO ₃	7631-99-4	12 000
2	Сульфокарбамид	Tiourea	SC(NH ₂) ₂	62-56-6	120
3	Аммонийн нитратын талсжих цэг бууруулагч	Ammonium Nitrate Crystallization inhibitory	-	-	180
4	Натрийн нитрит	Sodium nitrite	NaNO ₂	7632-00-0	300
5	Нимбэгний хүчил	Citric acid	C ₆ H ₈ O ₇	77-92-9	130
6	Азотын хүчил	Nitric acid	HNO ₃	7697-37-2	10
7	Натрийн ацетат	Sodium acetate	CH ₃ COONa	127-09-3	120
8	Цууны хүчил	Acetic acid	CH ₃ COOH	64-19-7	150
9	Цайрын нитрат	Zinc nitrate hexahydrate	Zn(NO ₃) ₂ ·6H ₂ O	10196-18-6	30
10	Карбамид	Urea	(NH ₂) ₂ CO	57-13-6	1100
11	Натрийн додецил сульфат	Sodium dodecyl sulphate	CH ₃ (CN ₂) ₁₁ OS O ₃ Na	151-21-3	65
12	Лаа, No	Composite wax, paraffine No	-	-	200
13	Лаа, NY-2	Composite wax, paraffine NY-2	-	-	900
14	Лаа, HN	Composite wax, paraffine HN	-	-	150
15	Лаа, LF	Composite wax, paraffine LF	-	-	125
16	Лаа	Wax, paraffine	-	-	200
17	Бичил талстат лаа	Microcrystalline wax	-	64742-60-5	200
18	Урсах цэг бууруулагч T803B	Pour point depressant T803B	-	-	30
19	Эмульсжүүлэгч	Emulsifier	-	-	2000
20	Эмульсжүүлэгч PIBSA NB4745,	Emulsifier PIBSA, Polyisobutenyl succinic anhydride, NB4745	-	67762-77-0	2000
21	Эмульсжүүлэгч PIBSA NB2424,	Emulsifier PIBSA, Polyisobutenyl succinic anhydride, NB2424	-	67762-77-0	2000
22	Эмульсжүүлэгч LR-1	Emulsifier, LR-1	-	-	150
23	Эмульсжүүлэгч SMO, S-80	Emulsifier /sorbitan monooleate/ SMO S-80	C ₂₄ H ₄₄ O ₆	1338-43-8	1500
24	Хөнгөн цагаан	Aluminum	Al	7429-90-5	100
25	Фосфорын хүчил	Phosphoric acid	H ₃ PO ₄	7664-38-2	150
26	Этилгексил фосфорын хүчлийн нийлмэл эфир	Phosphoric acid, 2-ethylhexul ester	C ₈ H ₁₇ O ₄ P ₂	12645-31-7	5
27	Нийлмэл тосон фаз	Composite oil phase (Oil blend)			9 000
28	Аммонийн тиоцианит	Ammonium thiocyanate	NH ₄ SCN	1762-95-4	15
29	Шилэн бөмбөлөг	Glass (hollow) microsphere		-	350
30	Хуванцар бөмбөлөг	Plastic (polyethylene, polymer) microsphere,		-	350
31	Перлит сувдан давс	Perlite	-	93763-70-3	200
32	Калийн нитрат	Potassium nitrate	KNO ₃	7757-97-1	12000
33	Полиакриламид	Polyacrylamide	(C ₃ H ₅ NO) _n	9003-05-8	5
34	Натрийн перхлорат	Sodium perchlorate	NaClO ₄	7601-89-0	215
35	Дизель түлш будагч	Fuel oil pigment	-	-	2

15/02